

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2021

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР – МОНГОЛ-ОРОСЫН ДИПЛОМАТ ХАРИЛЦААНЫ 100 ЖИЛД

Х.Бадамсүрэн¹

Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд оролцож байгаадаа миний бие баялаг бүтээгч уурхайчин хамт олныхоо өмнөөс болон хувиасаа талархал илэрхийлэхийн ялдамд 20 дугаар зууны Манлай бүтээн байгуулалт, Монгол Улсын Баатар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг босголцсон Орос ахан дүүстээ халуун мэнд дэвшүүлье.

Монгол оронд 1921 оны 7 дугаар сард Ардын хувьсгал ялж, мөн оны 11 дүгээр сард “Монгол, Оросын хоорондох найрамдлын барилдлагааг байгуулах тухай Монголын Ардын Засгийн газар ба Зөвлөлтийн Засагт Орос Улсын Засгийн газрын хэлэлцэн тогтоосон гэрээ бичиг” байгуулан, дипломат харилцаа тогтоосон нь мөнхийн хөрш Монгол, Оросын ард түмний харилцаанд шинэ үеийг эхлүүлсэн түүхтэй.

Монгол Улсад мал аж ахуй, газар тариалан, үйлдвэр, боловсрол, эрүүл мэнд, хотжилтыг хөгжүүлэх, дэлхийн II дайныг даван туулах, олон улсын тавцанд гарах, эдийн засгийн дэмжлэг үзүүлэхэд ЗСБНХУ, Зөвлөлт Оросын ард түмний үзүүлсэн хувь нэмэр үнэлж баршгүй их билээ. Үүний нэг тод жишээ бол XX зууны хамгийн том манлай бүтээн байгуулалт болох Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийг 1973-1978 онд байгуулсан явдал юм.

1969 оны хоёрдугаар сард МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлөөс ЗХУ-д хандан Булган аймаг дахь зэсийн ордын геологи хайгуулын ажилд оролцох, техник эдийн засгийн тооцоо хийлгэх, хамтран ашиглах талаар захидал илгээж санал тавьснаар Эрдэнэтийн зэс-молибдены хүдрийн орд газрыг хамтын ажиллагааны нэг том объект болгон ашиглах эхлэл тавигдсан. Улмаар бүх хөрөнгө оруулалтыг Зөвлөлтийн тал гаргаж 50 хувийг Монголын талд эзэмшүүлэх, Монголын талаас гаргах хөрөнгийг Зөвлөлтийн тал удаан хугацааны зээлээр өгөх асуудлыг Улаанбаатар хотод болсон Монгол, Зөвлөлтийн төлөвлөгөөний байгууллагуудын хамтарсан хуралдаанаар хэлэлцэж, 1972 онд Зөвлөлтийн мэргэжилтнүүдийн боловсруулсан ТЭЗҮ-г БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 305 дугаар тогтоолоор баталсан. Мөн оны 12 дугаар сард Эрдэнэтийн

¹ “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал, Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, Техникийн шинжлэх ухааны доктор /D.Sc./

овооны зэс, молибдены ордын анхдагч нөөцийг 521.7 сая тонн хүдэрт 3.4 сая тонн зэс, 89 мянган тонн молибдентой хэмээн баталж байсан бол хожим нь анх батлагдсан нөөцийг хэд хэдэн удаа шинэчлэн тогтоосноор дэлхийн ийм төрлийн томоохон ордуудын нэг болох нь батлагдсан.

1973 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Монгол-Зөвлөлтийн хамтарсан уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийг байгуулах тухай Засгийн газар хоорондын Хэлэлцээрт БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал, ЗСБНХУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга И.Т.Новиков нар гарын үсэг зурж, “Эрдэнэт” үйлдвэрийн эхний ээлжийн барилга байгууламжуудыг барих удирдамж, графикийг хэлэлцэн баталсан. Улмаар 1978 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Эрдэнэт үйлдвэрийн Баяжуулах үйлдвэрийн эхний ээлж ашиглалтад орж анхны баяжмалаа гарган авснаас хойш өдгөө үйлдвэрийн тээрмүүд 43 дахь жилдээ нүргэлж байна.

Энэхүү бүтээн байгуулалтын үр дүнд дэлхийд данстай, Ази тивдээ томоохонд тооцогдох уулын баяжуулах үйлдвэр байгуулагдсан төдийгүй уул уурхай дагасан, иж бүрэн дэд бүтэц бүхий Эрдэнэт хотыг цогцоор нь бүтээн босгосон юм. Энэ нь уул уурхайн томоохон төслийн сонгодог загвар, гадаадын хөрөнгө оруулалтыг зөв бодлого хэрэгжүүлэн, зөв менежментээр удирдаж чадвал Монгол улсынхаа хөгжлийг авч явах шилдэг жишээ болж байгааг харуулж байна.

Тухайн үед ЗСБНХУ нь Эрдэнэт үйлдвэрт хамгийн дэвшилтэт техник, технологийг суурилуулж, шилдэг боловсон хүчнээ ажиллуулж, манай шинэ үеийн өндөр боловсрол, нарийн мэргэжил, ур чадвартай ажилчид, мэргэжилтнүүдийг бэлтгэхэд үнэлж баршгүй туслалцаа үзүүлсэн юм.

1974 оноос хойш Эрдэнэт үйлдвэрийн 5000 гаруй монгол ажилтан, ажилчид ОХУ /ЗХУ/-ын их дээд сургууль, тусгай мэргэжлийн дунд сургууль, техник мэргэжлийн техникум, мэргэжил, мэргэшил дээшлүүлэх курс, орос хэлний курст мэргэжил, боловсрол эзэмшсэн байна.

1973-1978 оны хооронд Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэт хотыг бүтээн байгуулалцахаар ЗХУ-ын 15 бүгд найрамдах улсын 40 гаруй үндэстэн, ястны төлөөллөөс бүрдсэн 1500 гаруй барилгачид, мэргэжилтэн, инженерүүд гэр бүлийн хамт ирж байсан байна. Тэдгээрийн хүүхдүүдийг сургах зорилгоор 1975 онд Эрдэнэт хотод Орос сургууль, 1978 онд Орос, Монголын “Найрамдлын Эрдэнэт” хүүхдийн зуслан, 1979 онд Орос эмнэлэг, 1981 онд Орос цэцэрлэгийг тус тус барьж байгуулж байсан нь өнөөдрийг хүртэл “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын бүтцэд үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

Мөн уул уурхайн нарийн мэргэжлийн ажилчид, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх зорилгоор 1975 онд “Эрдэнэт” үйлдвэрийн Зөвлөлийн II хурлын шийдвэрийн дагуу “Сургалтын төв”-ийг байгуулж байсан нь одоогийн “Эрдэнэт

цогцолбор” дээд сургууль юм.

Энэ бол Зөвлөлтийн мэргэжилтнүүдийг тогтвор, суурьшилтай ажиллуулах, тэдгээрээс ирээдүйн уурхайчдыг бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх, алсыг харсан бодлогын бодит үр дүн бөгөөд түүхт 100 жилийн харилцааны тодоос тод жишээ мөн.

Эрдэнэт үйлдвэр нь 1978-2016 он хүртэл Монгол-Зөвлөлт /Орос/-ийн хамтарсан үйлдвэрийн статустайгаар 38 жил, 2016-2019 он хүртэл Монгол улсын хувийн өмчтэй хамтарсан компанийн статустайгаар 3 жил, 2019 оноос Монгол улсын 100 хувь төрийн өмчит үйлдвэрийн газрын статустайгаар 3 дахь жилдээ ажиллаж байна.

Өнөөдөр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т ОХУ-ын 150 гаруй мэргэжилтнүүд ажиллаж, тэдгээрийн ар гэрийнхэн нийлсэн 200 гаруй хүн Эрдэнэт хотод аж төрж байна.

Бид 2017 оноос хойш геологи хайгуулын ажилд нийтдээ 32.8 сая орчим ам.доллар зарцуулж ордын гүний хэсэгт хүдрийн нөөцийг нэмэгдүүлж, стратегийн ордын талбайн хүрээнд хэтийн төлөв бүхий хэд хэдэн талбайг нарийвчлан тогтоогоод байна. Түүнчлэн Эрдэнэтийн-Овоо ордын геологийн нөөцийг олон улсын ЖОРК стандартын дагуу баталгаажуулах ажлыг дуусгалаа. Ингэснээр Эрдэнэт үйлдвэрийн ашиглалтын хугацааг 30 орчим жилээр сунган, цаашид 70 гаруй жил ажиллах боломжтой болж байна.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн 2019 онд ОХУ-д хийсэн айлчлалын үеэр ОХУ-ын “Зарубежгеология” ХН-гэй “Геологи геофизикийн болон инженер-геологийн судалгааны салбарт хамтран ажиллах тухай” гэрээг байгуулж, хамтарсан судалгааны ажил хийгдэж байна.

Монгол Улсын Засгийн газар 2019 онд 224 дүгээр тогтоолыг баталж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын оруулах үр өгөөжийг нэмэгдүүлэх, үйлдвэрийн тогтвортой, урт хугацааны үйл ажиллагааг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлийг тодорхойлсон. Үүний дагуу “Эрдэнэт үйлдвэр”-ийг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэлийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 2019 онд баталсан. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь хөгжлийн үндсэн чиглэлд тусгасан Эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэх төсөл, Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэрийн төсөл, Исэлдсэн болон бага агуулгатай зэсийн хүдрийг нуруулдан уусгах - SX/EW технологиор боловсруулан катодын зэс үйлдвэрлэх төсөл, Засвар механикийн заводын өргөтгөл, шинэчлэлийн төсөл, Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн төсөл, Ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологийг нэвтрүүлэх төсөл зэрэг шинээр болон өргөтгөл шинэчлэлийн нийт 22 төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хоёр орны найрамдлын сарын аян, Аугаа их ялалтын баярыг жил бүр тэмдэглэдэг уламжлал тогтсоныг, цөөн үгээр хэлбэл, Орос ах нарын бүтээсэн бүхэн Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэт хотод айлчилж ирсэн хүн бүрд өнөөг хүртэл мэдрэгдэх нь хоёр орны харилцааны тод жишээ болохыг харуулж байна. Эрдэнэтэд төрж өссөн бараг хүн бүр орос хэлээр ярьж, дуулдаг нь хоёр орны хэл соёлын харилцаа өнгөрсөн жилүүдэд хөгжиж ирсний бас нэгэн тод хэлбэр мөн.

Монгол-Оросын найрамдалт, стратегийн түншлэл бүхий хамтын ажиллагааны хүрээнд бүтээгдэж, хөгжиж ирсэн “Эрдэнэт үйлдвэр” өнөөгийн хүнд цаг үед Монгол Улсынхаа айл өрх, аж ахуйн нэгжүүдээ дэмжих Засгийн газрын шийдвэрийг биелүүлэн ажиллаж байна.

Эрдэнэт үйлдвэрийн баялаг бүтээгч, уурхайчин хамт олон өнөөг хүртэл явуулж ирсэн үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар дотоодын эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх, дэлхийн түвшинд өрсөлдөх чадвараа дээшлүүлэхээр “Дэлхийн жишиг, Монголын бахархал”-ыг алсын хараагаа болгон урагшилж байна.

“Монгол-Оросын хамтын ажиллагаа – 100 жил” эрдэм шинжилгээний бага хуралд амжилт хүсье!